



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод ажиллас ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам”-ын 2 дугаар бүлэгт “2.2. Сургалтад хамрагдах төрийн албан хаагчийн хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсаар хүлээн авна.”, “2.9. Сургалтын цахим бүртгэлийн программ, түүний аюулгүй ажиллагааг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв хариуцан ажиллана.” гэсэн 2.2, 2.9 дэх заалтуудыг, 3.7 дахь хэсгийн “тохиолдолд” гэсний дараа “тухайн албан хаагчийн хүсэлтийг үндэслэн” гэж, 3.8 дахь хэсгийн “Төлөөлөгчдийн Хурал” гэсний дараа “, Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмсүгэй.

2. Мөн журмын 2.2 дахь хэсгийг “Төрийн албан хаагч цахим бүртгэлд бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг хавсаргана:” гэж, 2.4 дэх хэсгийг “Цахим бүртгэлд оруулсан баримт бичиг, мэдээллийн үнэн зөвийг тухайн албан хаагч өөрөө хариуцана.” гэж, 2.5 дахь хэсгийг “2.5. Сонгуулийн ерөнхий хороо шаардлагатай гэж үзвэл бүртгэлд хамрагдсан төрийн албан хаагчийн мэдээлэл, баримт бичгийг нягтлан шалгах зорилгоор нэмэлт мэдээлэл авч болно.” гэж, 3.6 дахь хэсгийн “олгоно.” гэснийг “олгох бөгөөд гэрчилгээтэй төрийн албан хаагчдын жагсаалтыг цахим хуудастаа байршуулна.” гэж, 3.7 дахь хэсгийн “дугаар, тусгай нууцлалтай” гэснийг “дугаартай” гэж тус тус өөрчилсүгэй.


3. Мөн журмын 2.1 дэх хэсгийн “, сургалт зохион байгуулах” гэснийг, 2.3, 2.6 дахь хэсгийг тус тус хассугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР



00000016